



**ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТЭРГҮҮЛЭГЧДИЙН ТОГТООЛ**

2016 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 59.

Алтай

Нэрэмжит болгох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.12, Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 172 дугаар тогтоолоор батлагдсан "Түүхэн үйл явдлын ой, тэмдэглэлт өдрийг тэмдэглэх, гавьяат үйлстнийг алдаршуулах, дурсгалыг мөнхжүүлэх журам"-ын 6 дахь хэсгийн 6.4 дэх заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Аймгийн Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгыг Монгол Улсын төрийн хошой шагналт, эрдэмтэн зохиолч Чадраабалын Лодойдамбын нэрэмжит болгосугай.

2. Монгол Улсын төрийн хошой шагналт, эрдэмтэн зохиолч Ч. Лодойдамбын нэрэмжит аймгийн Ардын дуу бүжгийн "Алтай" чуулгын хаяг, албан хуудасны загварыг баталж, нэрэмжит болгосонтой холбоотой ажил үйлсийг хойч үеийнхэнд таниулж, гавьяат үйлсийг нь алдаршуулан ажиллахыг аймгийн Засаг дарга /С.Гансэлэм/-д даалгасугай.

ДАРГА  Т.ГАНЗОРИГ